

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар АН/6

Сүмбэр сум

Болзошгүй осол, гал түймэр,
цахилгааны аюулаас объектыг хамгаалах,
урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хөрөнгө
зарцуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 17 дугаар зүйлийн 17.2.4, 17.2.10, 19 дүгээр зүйлийн 19.3, 19.8, Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага норм MNS 5566:2020-ын 4.3, Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын гал түймрийн улсын байцаагчийн 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 41/59 дугаар бүхий Заавал биелүүлэх албан шаардлагын биелэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Болзошгүй осол, гал түймэр, цахилгааны аюулаас объектыг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тайлагнаж ажиллахыг Хүүхдийн эрхийн Улсын байцаагч (Б.Шархүү) -д үүрэг болгосугай.


3. Үйл ажиллагаанд зарцуулагдах 674 000 /зургаан зуун дөрвөн мянга/ төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д.Оюунцэцэг) -д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНБИЛЭГ

ГБХЗХгазрын даргын 2021 оны
06 сарын 05 -ны өдрийн
дугаар тушаалын 1-р хавсралт



**БОЛЗОШГҮЙ ОСОЛ, ГАЛ ТҮЙМЭР, ЦАХИЛГААНЫ АЮУЛААС
ОБЪЕКТЫГ ХАМГААЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

2021.06.03

НЭГ. Үндэслэл

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 17 дугаар зүйлийн 17.2.4, 17.2.10, 19 дүгээр зүйлийн 19.3, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага норм MNS 5566:2020-ын 4.3, Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын гал түймрийн улсын байцаагчийн 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 41/59 дугаар бүхий Заавал биелүүлэх албан шаардлагын биелэлтийг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх.

ХОЁР. Зорилго

Хүүхдийн эрх, хамгаалал, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүүхэд хамгааллын орчныг сайжруулах. Байгууллагын объектын цахилгааны эрсдэлийг тодорхойлж аюулгүй байдлыг хангах, албан хаагчдын гал түймэртэй тэмцэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд сургах, мэдлэгийг дээшлүүлэх.

ГУРАВ. Хугацаа

2021.06.04-2021.06.11-ний хооронд зохион байгуулан ажиллана.

ДӨРӨВ. Хамтран ажиллах байгууллага

Аймгийн Онцгой байдлын газар

ТАВ ЗУРГАА. Зохион байгуулалт

Хамтран ажиллах байгууллагын томилогдсон албан хаагчид дараах хуваарийн дагуу ажиллана.

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хамтран ажиллах байгууллага, хувь хүн	Хариуцах эзэн
1	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	2021 оны 06 сарын 04	ОБГ	Б.Шархүү
2	Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, шуурхай карт	2021 оны 06 сарын 04	ОБГ	Б.Шархүү

D:/Бичиг хэрэг /тушаал


	боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулах.			
3	Гал унтраах анхан шатны багажийг нэмэгдүүлэх	06.04-06.11	Б.Шархүү, Нягтлан бодогч	Нярав
4	Галын дохиоллын хэрэгсэл утаа мэдрэгчийг объектэд байрлуулах	06.04-06.11	Б.Шархүү, Нягтлан бодогч	Нярав
5	Хүний амь аврах зам гарцын тэмдэг, тэмдэглэгээ, объектын план зураг, урьдчилан сэргийлэх самбар, аваарын гэрэлтүүлэг, гал унтраагуул байршуулах	06.04-06.11	Б.Шархүү, Нягтлан бодогч	Нярав
6	Ажилтан албан хаагчдад гал түймэртэй тэмцэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх	2021 оны 06 сарын 04	ОБГ	Б.Шархүү
7	Байгууллагын хүчдэл тэмдэглэгээ хийх, цахилгаан буулгах, салгах схем зураглал, хүчдэл аюултай гэсэн анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	06.04-06.11	Б.Шархүү, Нягтлан бодогч	Нярав
8	Архивын өрөөнд урьдчилан сэргийлэх самбар, план зураг байршуулах	06.04-06.11	Б.Шархүү, Нягтлан бодогч	Бичиг хэрэг

ЗУРГАА. Үр дүн

Болзошгүй осол, гал түймэр, цахилгааны аюулаас объектыг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлын тайлангийн эхний явцыг 6 дугаар сарын 7-ны өдөр холбогдох байгууллагад хүргүүлнэ.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
ХҮҮХДИЙН ЭРХИЙН УЛСЫН БАЙЦААГЧ *Б.Шархүү* Б.ШАРХҮҮ

ГБХЗХгазрын даргын 2021 оны
06 сарын 03 -ны өдрийн
дугаар тушаалын 2-р хавсралт



БОЛЗОШГҮЙ ОСОЛ, ГАЛ ТҮЙМЭР, ЦАХИЛГААНЫ АЮУЛААС
ОБЪЕКТЫГ ХАМГААЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

2021.06.03

№	Үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Шаардлагатай тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Галын дохиолол /утаа мэдрэгч/	ширхэг	8	26000	208000
2	Гарцын тэмдэг /план зураг/	Ширхэг	2	17000	34000
3	Аваарын гэрэлтүүлэг	ширхэг	2	27000	54000
4	Гал унтраагуул	ширхэг	2	55000	110000
5	Гал унтраагуул тогтоогч	ширхэг	4	12000	48000
6	Хүчдэл аюултай, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ	ширхэг	2	4500	9000
7	Галын самбар /жигжиг/	ширхэг	1	16000	16000
8	Хүрз	ширхэг	2	15000	30000
9	Жоотуу	ширхэг	1	16000	16000
10	Хувин	ширхэг	2	15000	30000
11	Гөвүүр	ширхэг	2	5000	10000
12	Шүршдэг улаан будаг	ширхэг	7	3500	24500
13	Лоом	ширхэг	1	18000	18000
14	Сүх	ширхэг	1	18000	18000
15	Гарцын тэмдэг /EXIT/	ширхэг	3	12000	36000
16	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах		1	12500	12500
Нийт					674000

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН:
ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
ХҮҮХДИЙН ЭРХИЙН УЛСЫН БАЙЦААГЧ *Б.ШАРХҮҮ* Б.ШАРХҮҮ